



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

200.7 оны 01 дугаар
сарын 08 -ны одор

Дугаар 101

Улаанбаатар хот

Дүрэм, бүтэц, орон тоог
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, Засгийн газрын 2000 оны 185 дугаар тогтоолын 8 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх "Эрүүл мэндийн газар"-ын дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Эрүүл мэндийн газрыг орлогч дарга 1, Удирдлага төлөвлөлт, мэдээллийн хэлтэс, Нийгмийн эрүүл мэнд эмнэлгийн тусламжийн хэлтэстэйгээр орон тооны хязгаарыг 17 хүртэл байхаар тогтоосугай.

Газрын орлогч дарга нь Удирдлага төлөвлөлт, мэдээллийн хэлтсийн дарга байна.

Гурав. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоох, байгууллагын дотоод журмыг шинэчлэн мөрдөх, үйл ажиллагааны стратеги, хэтийн чиглэлийг боловсруулан энэ оны эхний хагас жилд багтаан батлуулах ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн газар /Ц.Ганхүү/-т даалгасугай.

Дөрөв. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 1997 оны Б/59 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД

Нийслэлийн Засаг даргын 2001 оны
12 дугаар захирамжийн хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газар нь /цаашид "газар" гэх/ нийслэлийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, эмчилгээ үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажлын чанарыг сайжруулах, шинэ техник төхөөрөмж, шинжлэх ухааны орчин үеийн арга нэвтрүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны орон нутгийн байгууллага мөн.

1.2. Газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Эрүүл мэндийн багц хуулиуд, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжууд, төрөөс хүн амын эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, Нийслэлийн Иргэдийн Толоологчдийн Хурлын тогтоол, Засаг даргын мөрийн хөтөлбөр, захирамж, энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.3. Газар нь Нийслэлийн Засаг дарга, орлогч, Тамгын газрын удирдлаганд үйл ажиллагаагаа явуулж, ажлаа тайлагнана.

1.4. Газрын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтоож, даргыг томилж чөлөөлнө.

1.5. Газрын дарга нь эрх хэмжээний асуудлаар тушаал гаргана.

1.6. Газрын дарга нь батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилж, чөлөөлнө.

1.7. Газрын дарга нь нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр орлогч даргаа томилж, чөлөөлнө.

1.8. Газар нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд харилцах данстай байна.

1.9. Газрын даргын дэргэд байгууллагын зорилт, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж байх зөвлөлийг ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг газрын дарга батлана.

1.10. Газар нь хүн амын эрүүл мэндийг хамгаалах бэхжүүлэх чиглэлээр "сан"-тай байж болно.

Хоёр. Газрын үүрэг

2.1. Монгол улсын Засгийн газар, Нийслэлийн засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх.

2.2. Эрүүл мэндийн талаар холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг даалгаврыг нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг хугацаанд нь тайлагнаж ажиллах.

2.3. Нийслэлийн хүн амд нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, үйлчилгээг чанар, хүртээмжтэй үзүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцон, өвчлөл, нас баралтыг бууруулах, наслалтыг уртасгах.

2.4. Хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгаа нийгэм, эдийн засаг, орчны зэрэг хүчин зүйлийг судлан тогтоож, арилгах арга хэмжээг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, харъяа мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх.

2.5. Харъяа эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгон шинэчлэх, өөрчлөх, материаллаг баазыг бэхжүүлэх, үйл ажиллагааг нь зохицуулах асуудлыг санаачлан эрх хэмжээнийхээ хүрээнд болон удирдах байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

2.6. Нийслэлийн хэмжээнд эм био бэлдмэл, эмнэлгийн багаж хэрэгсэл, аппарат, тоног төхөөрөмж, техникийн судалгаа, төлөвлөлт, санхүүжилтийн асуудлыг Эрүүл мэндийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт оруулж шийдвэрлүүлэх, тендер зарлаж дүгнэх, бэлтгэн нийлүүлэх.

2.7. Эрүүл мэнд, эмнэлэг, эм биобэлдмэл, эрүүл ахуй, халдвар судлалын тусламж үйлчилгээнд дэвшилтэт шинэ арга барил, технологийг нэвтрүүлэх, эмч, боловсон хүчний мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх.

2.8. Эмнэлгийн тусламж үйлчилгээний багц стандарт, технологийн мөрдөлт, хэрэгжилт, үр дүнг тооцоолж холбогдох арга хэмжээ авах.

2.9. Нийслэлд үйл ажиллагаагаа явуулж буй улс, хотын үйлчилгээтэй төрийн өмчийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаа, санхүү, эдийн засаг, хүн хүчний тайлан мэдээг сар, улирал, жилээр авч нэгтгэн үнэлэлт дүгнэлт гарган холбогдох дээд байгууллагад мэдээлэх.

2.10. Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгаа явуулах, бие бялдрыг чийрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх, хүн ам зүйн холбогдолтой мэдээллийг хүлээн авч нэгтгэн дүгнэх.

2.11. Эмнэлгийн боловсон хүчнийг сургах, давтан бэлтгэх, мэргэжлийн ур чадвар, хариуцлага, ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх, туршлага судлуулах асуудлаар олон улсын төсөл хэрэгжүүлэх, гадаад улс орны ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах.

2.12. Хүн амын дунд зонхилж байгаа зарим өвчнийг бууруулах, эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр урт, богино хугацааны хөтөлбөр, төсөл боловсруулан батлуулж, биелэлтийг нь хангуулах.

2.13. Нийслэлийн эрүүл мэндийн салбарын барилга байгууламжийн өргөтгөл, шинэчлэлт, их засварын ажлын төлөвлөлт, санхүүжилтийн асуудлыг

Эрүүл мэндийн яам, нийслэлийн Засаг даргын тамгын газарт оруулж шийдвэрлүүлэх, салбарын захиалагчийн үүргийг гүйцэтгэх.

2.14. Газрын даргын нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалыг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэст ирүүлж хянуулна.

2.15. Байгууллагын хэмжээнд сахилга дэг журам, төрийн албан хаагчдын ёс зүйн хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллах.

Гурав. Газрын эрх

3.1. Харьяа байгууллагуудын удирдах албан тушаалтныг томилох, томилоход санал өгөх, тэдний ажлын талаар санал дүгнэлт гаргах.

3.2. Харьяа байгууллагуудын зохион байгуулалтын бүтцийг батлах, тэдгээрийг байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах асуудлыг зохих журмын дагуу нийслэлийн Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлэх.

3.3. Хүн амын эрүүл мэндийн асуудлаар аж ахуйн нэгж, байгууллагын ажлыг шалгаж зөвлөх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах.

3.5. Нийслэлийн иргэдийн эрүүл мэндтэй холбоотой асуудлаар байгууллага, иргэдээс мэдээ мэдээллийг гаргуулж авах.

3.6. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад зөвшөөрөл олгох, хянах, үйл ажиллагааг нь түр зогсоох, хаах хүртэл арга хэмжээ авах.

3.7. Харьяа байгууллагуудын үйл ажиллагааны жил, хэтийн зорилт, төсвийн төслийг нэгтгэн боловсруулах, газрын батлагдсан төсвийг захиран зарцуулж тайлагнах.

3.8. Төгсөлтийн дараах мэргэжил олгох, дээшлүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгцээг тогтоох, мэргэжлийн боловсон хүчнийг зөв байршуулах.

3.9. Эмчилгээ үйлчилгээ, эм биобэлдмэл, эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтыг зохион байгуулж, зөрчлийг арилгуулах, хууль зүйд нийцүүлэн хариуцлага хүлээлгэх.

3.10. Хүн амын эрүүл мэндийг хамгаалахад дэмжлэг туслалцаа үзүүлсэн орон нутгийн төр захиргааны байгууллагын ажилтан, аж ахуйн нэгж, иргэд, идэвхтэн, тэргүүний ажилтай эмч, ажилчдыг эрхийн хүрээнд шагнаж урамшуулах, нийслэл, яам, төрийн шагналд тодорхойлох.

3.12. Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн болон хууль тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдлэнэ.